

УЛААНБААТАР ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ТӨХК



**“ХАМГААЛАХ БАГАЖ ХЭРЭГСЭЛ” НИЙЛҮҮЛЭГЧИЙГ
СОНГОН ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Тендерийн нэр: **Хамгаалах багаж хэрэгсэл**

Тендерийн дугаар: **ХА-014/2020**

Улаанбаатар хот - 2020 он

ЦАХИМ ТЕНДЕРИЙН УРИЛГА

2020 оны 03 дугаар сарын 18-ны өдөр

Тендерийн нэр: **ХАМГААЛАХ БАГАЖ ХЭРЭГСЭЛ**

Тендерийн дугаар: **ХА-014/2020**

“УБЦТС” ТӨХК эрх бүхий тендерт оролцогчдоос **“Хамгаалах багаж хэрэгсэл”** нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүйгээр татан авна уу. Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын 2013 оны 07 дугаар тушаалаар батлагдсан “Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам”-ын дагуу зохион байгуулж байна.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө **50,000 /тавин мянга/** төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендерийг **2020 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 09 цаг 00 минутаас** өмнө системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2020 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 09 цаг 15 минутад** тендерийн нээлтийн өрөөнд нээнэ. /УБЦТС ТӨХК-н төв байрны 206 тоот/

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй.

Дотоодын давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Захиалагчийн хаяг:

Улаанбаатар хот. Хан-Уул дүүрэг. 3-р хороо,

Чингисийн өргөн чөлөө-45.

**УБЦТС ТӨХК-ийн төв байр. 206 тоот. Хангамж
үйлчилгээний алба Утас: 342420 +157, Факс: 976-341852**

Цахим хаяг: www.tender.gov.mn

Хёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**

1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**

2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.

2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**

3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

 - (а) Үнийн санал;
 - (б) Үнийн боло нийлүүлэлтийн хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тогтмол үнэ**

4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**

5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.

5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
- 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**

6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<ol style="list-style-type: none"> 1. Сүүлийн нэг жил буюу 2019 оны санхүүгийн аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх 2. Борлуулалтын орлого сүүлийн 1 жил буюу /2019 он/ санал болгож буй үнийн дүнтэй дүйцэхүйц 3. Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл /Хөдөлмөр хамгааллын багаж нийлүүлж байсан туршлагатай байх, гэрээний хуулбар, бараа хүлээлцсэн акт, протокол ирүүлнэ./ <p style="text-align: center;"><u>Нэмэлт шаардлага</u></p> <ol style="list-style-type: none"> 4. Компанийн дэлгэрэнгүй танилцуулга 5. Улсын бүртгэлийн гэрчилгээ 6. Үнийн саналыг маягтын дагуу ирүүлэх. Төсөвт өртөг / 46,669,300 төгрөг / 7. Бараа нийлүүлэлтийн хуваарь /Гэрээний дагуу/ 8. Үйлдвэрлэгчийн зөвшөөрөл ирүүлнэ. 9. ШШГЕГ-ын тодорхойлолт 10.Татварын тодорхойлолт /тендер нээсэн өдрийн байдлаар татварын өргүй байна./ 11.Гэрээний үнэ, хугацаанд хийж гүйцэтгэж, хүлээлгэж өгөхийг баталсан албан мэдэгдэл ирүүлнэ. 12.Тендерт оролцогч Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14.1-д заасан нөхцөл байхгүйг бичгээр мэдээлнэ. 13.Чанарын баталгаат хугацаа 12 сар 14.Техникийн тодорхойлолтын шаардлага хангасан эсэх тухай харьцуулсан хүснэгт ирүүлнэ. 15.Нийлүүлэх барааны зураг, үйлдвэрлэгчийн каталогийн эх хувийг ирүүлнэ. Каталог дээрээс санал болгож буй барааг ялган тодруулж ирүүлнэ. Тендерийн хэл нь Монгол хэл тул гадаад хэл дээрх аливаа материалыг баталгаат орчуулгаар Монгол хэл рүү орчуулан баталгаажуулан ирүүлнэ. 16.Олон улсын чанарын стандартын шаардлага хангасан эсэхийг гэрчилэх гэрчилгээ, сертификатыг хавсарган ирүүлнэ. 17.Тендерийн баримт бичгийн 5,6 дугаар бүлэгт заагдсан гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл, тендерийн баримт бичгийн маягт зэргийг зөвшөөрч байгаа талаар мэдэгдэл ирүүлнэ. 18.Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.

<p>ТӨӨЗ 2.1</p>	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Уг тендер нь цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь Цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn)-д өөрийн аж ахуйн нэгжийн хувийн нууцлалын кодоор нэвтрэн орж тендерийн материалаа цахим хэлбэрээр ирүүлнэ. Харилцах утас: 976-11-342420+157, 158</p> <p>Байгууллагын хаяг: Хан-уул дүүрэг 3-р хороо Чингисийн өргөн чөлөө-45, "УБЦТС" ТӨХК-ийн төв байр.</p> <p>Давхар болон өрөөний дугаар: 2-р давхар, 206 тоот өрөө Огноо: 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдөр Цаг: 09 цаг 00 минут</p> <p>Цахим тендерийн урилгад заасан тендер хүлээн авах эцсийн хугацаа нь цахим системийн серверийн цагаар тооцогдох бөгөөд хугацаа хоцорсон тендерийг хүлээж авахгүй.</p>
<p>ТӨӨЗ 2.1</p>	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Хан-уул дүүрэг 3-р хороо Чингисийн өргөн чөлөө-45, "УБЦТС" ТӨХК-ийн төв байр</p> <p>Давхар болон өрөөний дугаар: [2-р давхар, 206 тоот өрөө]</p> <p>Огноо: 2020 оны 03 дугаар сарын 25 -ны өдөр</p> <p>Цаг: 09 цаг 15 минут</p>
<p>ТӨӨЗ 2.3</p>	<p>Дөрөвдүгээр бүлгийн маягтуудаас гадна эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. [Тендерт оролцогчийг эрх бүхий болохыг нотлохтой холбоотойгоор ТШӨХ-д заасан бүх баримт бичгийг жагсаан бичих] 2. ... 3.
<p>ТӨӨЗ 6.2</p>	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Багцгүй ХА-014/2020 Хамгаалах багаж хэрэгсэл</p>

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. **Барааны тодорхойлолт:** Хамгаалах багаж хэрэгсэл
2. **Стандарт:** Захиалагч холбогдох стандартыг заана.
3. **Баглаа, боодол:** Барааг тээвэрлэх, хадгалах үеийн баглаа боодолд тавих нөхцөлийг тодорхой заана. Ачааг хэрхэн тэмдэглэх болон хаяглах, ямар баримт бичиг дагалдахыг энд тодорхойлно.
4. **Бараа хүргэх газар:** УБЦТС ТӨХК-ийн төв агуулах
5. **Бараа нийлүүлэлтийн хуваарь:** Гэрээний дагуу


БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ


	Нэр	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
	1	3	4	5	6	7	8
1	Хөндийрүүлэх бахь 0,4 кВ /нарийн хошуутай/	85	ш	УБЦТС ТӨХК-ийн Төв дэх агуулах	Гэрээний дагуу	Гэрээний дагуу	
2	Хөндийрүүлэх бахь 0,4 кВ /энгийн хошуутай/	314	ш				
3	Хөндийрүүлэгчтэй халив 0,4 кВ /нэмэх хошуутай/	509	ш				
4	Хөндийрүүлэгчтэй халив 0,4 кВ /хасах хошуутай/	505	ш				
5	Хошуувч /олон удаагийн/	767	ш	УБЦТС ТӨХК-ийн Төв дэх агуулах	Гэрээний дагуу	Гэрээний дагуу	
6	Хүчдэл заагуур /0,4 кВ /	1046	ш				
7	Хүчдэл заагуур /6,10 кВ	7	ш				
8	Машин механизмын зөөврийн газардуулгын утас /зэс d16мм*4 м/	13	ш				
	НИЙТ	3246	ш				



Жич: Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө нийлүүлэх бараанаас загвар ирүүлнэ. Хэрэв ирүүлээгүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.





Техникийн тодорхойлолт


0.4кВ-ын бахь, халив, 0.4-10кВ-ын хүчдэл заагуур, механизмын зөөврийн газардуулга, хошуувчинд тавигдах техникийн шаардлага

Д/Д	Материалын нэр	Техникийн үзүүлэлт	Зориулалт	Тайлбар
1	<p>Хосолмол үйлдэлт (200мм-ийн) бахь /1кВ хүртэл/</p> 	<p>MNS ISO 5746:2004 стандартын шаардлагыг хангасан байна</p> <ol style="list-style-type: none"> Бахьны толгойн хэсэг нь метал хийцтэй, ажлын хэсэг, нугасны хэсэг гэж зааглагдана. Ажлын хэсэг /тоноглолд хүрч үйлдэл хийх/ нүүрстөрөгчийн ган төмөр ISO 6508:86 шаардлагыг /хром никель ган бүтэцтэй/ хангасан, эрүү хэсэг /хавчих/, зуурах хэсэг /багалзуурдах/, зууш хэсэг /таслах, шалбалах/ гэсэн бүтэцтэй, хавчих хэсгийн үзүүрээс таслах хэсгийн уг хүртэлх урт 0.04м /40мм ± 8мм/ орчим. Энэ хэмжээст нугасны хэсэг /ажлын хэсэг, бариул хэсгийн хоорондох хөдөлгөөнт үе/ орохгүй. Бариулын хэсэг /гар хүрч харьцах/ метал их биетэй гадуураа тусгаарлах материал бүхий гар гулгахгүй хэлбэртэй хөндийрүүлэх резин гадаргуутай, бариулын хэсгийн урт 0.12м /12мм ± 8мм/ орчим, техникийн өгөгдлийн бичлэгтэй байна. Бахьны толгойн хэсэг /ажлын хэсэг болон нугасны хэсэг орсон/-ийн өргөн 0.032м-ээс илүүгүй, толгойн зузаан 0.014м-ээс илүүгүй. Бахьны ажлын хэсэг, нугасны хэсэг, бариулын хэсэг орсон нийт уртын хэмжээ 0.2 м /200мм ± 11мм/ орчим. Температурын горим: -40°C-:+40°C Бахьны эрүү хэсгээр 3мм зузаантай, 16мм өргөнтэй, хатуулгын хэмжээ нь 30-45 HRC найрлагатай материалыг 50Н ачааллын хүчээр атган хавчихад бахьны бүтэц болон бариул хэсэг деформаци /гажилт/-д орохгүй. Бахьны эрүү болон зуурах хэсгээр 3мм зузаантай, 12мм өргөнтэй, 8мм урттай хатуулгын хэмжээ нь 30-45 HRC найрлагатай материалыг хавчин 20Н*м хүчээр 20° /градус/ өнцгөөс ихгүй мушгих болон хөшихөд бахь болон бариул хэсэг гажилтанд орохгүй. Бахьны таслах хэсгээр 1 мм зузаан, 10 мм өргөн, дундаж хатуулагтай /зэс, цагаан тугалга, хөнгөн цагаан, хүрэл/ утсыг 740-830 МПа хүчээр дарах буюу хавчин таслахад таслах ир эвдрэлд орохгүй, бахь болон бариул хэсэг гажилтанд орохгүй. 1кВ хүртэл хүчдэлтэй хувьсах гүйдлийн тоноглолд, 1.5кВ хүртэл хүчдэлтэй тогтмол гүйдлийн тоноглолд хүрч ажиллахад хүний аюулгүй байдлыг хангах Жин 0.390кг-аас ихгүй 	Цахилгаан монтажны ажилд хүнийг тусгаарлах, хосолмол үйлдэлт багаж	Хосолмол үйлдэлт бахьны үйлдвэрлэгчийн техникийн өгөгдөл буюу багаж дээрх бичлэг бичилт, багажны пайз буюу дагалдах бичиг баримт хоорондоо тохирсон байна.

<p>2</p>	<p>Нарийн хошуутай, хосолмол үйлдэлт (160мм-ийн) бахь /1кВ хүртэл/</p> 	<p>MNS ISO 5746:2004 стандартын шаардлагыг хангасан байна</p> <ol style="list-style-type: none"> 1.Бахьны толгойн хэсэг нь метал хийцтэй, ажлын хэсэг, нугасны хэсэг гэж зааглагдана. Ажлын хэсэг /тоноглолд хүрч үйлдэл хийх/ нүүрстөрөгчийн ган төмөр ISO 6508:86 шаардлагыг /хром никель ган бүтэцтэй/ хангасан, эрүү хэсэг /хавчих/ үзүүрлүүгээ нарийссан хийцтэй, зууш хэсэг /таслах, шалбалах/ гэсэн бүтэцтэй, хавчих хэсгийн үзүүрээс таслах хэсгийн уг хүртэлх урт 0.05м /50мм ± 8мм/ орчим. Энэ хэмжээст нугасны хэсэг /ажлын хэсэг, бариул хэсгийн хоорондох хөдөлгөөнт үе/ орохгүй. 2.Бариулын хэсэг /гар хүрч харьцах/ метал их биетэй гадуураа тусгаарлах материал бүхий гар гулгахгүй хэлбэртэй хөндийрүүлэх резин гадаргуутай, бариулын хэсгийн урт 0.12м /12мм ± 8мм/ орчим, техникийн өгөгдлийн бичлэгтэй байна. 3.Бахьны ажлын хэсэг, нугасны хэсэг, бариулын хэсэг орсон нийт уртын хэмжээ 0.16 м /160мм ± 11мм/ орчим. 4.Температурын горим: -40°C-:+40°C 5.Бахьны таслах хэсгээр 2.2 мм диаметртэй зэс утас, 2.0 мм диаметртэй төмөр утас, 1.6 мм диаметртэй ган утсыг 650-740 МПа хүчээр дарах буюу хавчин таслахад таслах ир эвдрэлд орохгүй, бахь болон бариул хэсэг гажилтанд орохгүй. 6.1кВ хүртэл хүчдэлтэй хувьсах гүйдлийн тоноглолд, 1.5кВ хүртэл хүчдэлтэй тогтмол гүйдлийн тоноглолд хүрч ажиллахад хүний аюулгүй байдлыг хангах 7.Жин 0.240кг-аас ихгүй 	<p>Цахилгаан монтажны ажилд хүнийг тусгаарлах, хосолмол үйлдэлт багаж</p>	<p>Нарийн хошуутай хосолмол үйлдэлт бахьны үйлдвэрлэгчийн техникийн өгөгдөл буюу багаж дээрх бичлэг бичилт, багажны пайз буюу дагалдах бичиг баримт хоорондоо тохирсон байна.</p>
----------	--	---	---	---

3	<p>Хөндийрүүлэгтэй (100мм-ийн) хасах хошуутай халив /1кВ хүртэл/</p> 	<p>MNS ISO 5746:2004 стандартын шаардлагыг хангасан байна</p> <ol style="list-style-type: none"> 1.Халивны ажлын хэсэг /тоноглолд хүрч үйлдэл хийх/ нүүрстөрөгчийн ган төмөр ISO 6508:86 шаардлагыг /хром ванадим ган бүтэцтэй/ хангасан, ажлын хэсгийн үзүүр хавтгай шулуун толгойтой, урт 0.015м /15мм ± 6мм/ орчим. 2.Иш нь ажлын хэсэг, бариул хэсгийг заагласан металл их биетэй, гадуураа тусгаарлах материал бүхий гадаргуутай, техникийн өгөгдлийн бичлэгтэй байна. 3.Бариулын хэсэг /гар хүрч харьцах/ метал их биетэй гадуураа тусгаарлах материал бүхий гар гулгахгүй хэлбэртэй хөндийрүүлэх резин гадаргуутай, бариулын хэсгийн урт 0.10м /10мм ± 8мм/ орчим. 4.Халивны хэмжээс /размер/ PH2x100. 5.Температурын горим: -20°C-:+70°C 6.Толгойн хэсгийн хатуулаг 48-:-52HRCe, хэмжээс /размер/ M3.5-:-M5, соронзтой. 7.Халивны ажлын хэсгээр 50Н*м эргэлтийн хүчээр үйлчлэхэд ажлын хэсгийн толгой, иш, бариул хэсэг гажилтанд орохгүй. 8.1кВ хүртэл хүчдэлтэй хувьсах гүйдлийн тоноглолд, 1.5кВ хүртэл хүчдэлтэй тогтмол гүйдлийн тоноглолд хүрч ажиллахад хүний аюулгүй байдлыг хангах 9.Жин 0.120кг-аас ихгүй 	<p>Цахилгаан монтажны ажилд хүнийг тусгаарлах, чангалж суллах, мушгих багаж</p>	<p>Хөндийрүүлэгтэй халивны үйлдвэрлэгчийн техникийн өгөгдөл буюу багаж дээрх бичлэг бичилт, багажны пайз буюу дагалдах бичиг баримт хоорондоо тохирсон байна.</p>
4	<p>Хөндийрүүлэгтэй (100мм-ийн) нэмэх хошуутай халив /1кВ хүртэл/</p> 	<p>MNS ISO 5746:2004 стандартын шаардлагыг хангасан байна</p> <ol style="list-style-type: none"> 1.Халивны ажлын хэсэг /тоноглолд хүрч үйлдэл хийх/ нүүрстөрөгчийн ган төмөр ISO 6508:86 шаардлагыг /хром ванадим ган бүтэцтэй/ хангасан, ажлын хэсэг нэмэх хэлбэртэй нарийссан үзүүртэй, урт 0.015м /15мм ± 6мм/ орчим. 2.Иш нь ажлын хэсэг, бариул хэсгийг заагласан металл их биетэй, гадуураа тусгаарлах материал бүхий гадаргуутай, техникийн өгөгдлийн бичлэгтэй байна. Ишний урт 0.10 м /100мм ± 6мм/ орчим. 3.Бариулын хэсэг /гар хүрч харьцах/ метал их биетэй гадуураа тусгаарлах материал бүхий гар гулгахгүй хэлбэртэй хөндийрүүлэх резин гадаргуутай, бариулын хэсгийн урт 0.10м /10мм ± 8мм/ орчим. 4.Халивны хэмжээс /размер/ PZ2x100. 5.Температурын горим: -20°C-:+70°C 6.Толгойн хэсгийн хатуулаг 48-:-52HRCe, хэмжээс /размер/ M3.5-:-M5, соронзтой. 7.Халивны ажлын хэсгээр 50Н*м эргэлтийн хүчээр үйлчлэхэд ажлын хэсгийн толгой, иш, бариул хэсэг гажилтанд орохгүй. 8.1кВ хүртэл хүчдэлтэй хувьсах гүйдлийн тоноглолд, 1.5кВ хүртэл хүчдэлтэй тогтмол гүйдлийн тоноглолд хүрч ажиллахад хүний аюулгүй байдлыг хангах 9.Жин 0.120кг-аас ихгүй 	<p>Цахилгаан монтажны ажилд хүнийг тусгаарлах, чангалж суллах, мушгих багаж</p>	<p>Хөндийрүүлэгтэй халивны үйлдвэрлэгчийн техникийн өгөгдөл буюу багаж дээрх бичлэг бичилт, багажны пайз буюу дагалдах бичиг баримт хоорондоо тохирсон байна.</p>

5	 <p>Нэг туйлт хүчдэл заагуур /0.4кВ/</p> 	<ol style="list-style-type: none"> 1. Хүчдэл заагуурын урт /сунгасан үед/ 0.8м-ээс ихгүй, тээврийн байрлалд /эвхсэн үед/ 0.24м-ээс ихгүй 2. Тусгаарлах хэсэг /ажлын хэсгээс бариул хүртэлх/ цахилгаан гүйдэл дамжуулахгүй тусгаарлах материал /бакелит, пластмас, мод, тос шингээсэн тусгаарлагч/ -аар хийгдсэн, тусгаарлах хэсгийн урт 0.24м –ээс багагүй 3. Бариулын хэсэг /гар хүрч харьцах/ тусгаарлах материалтай, гар гулгахгүй хэлбэр бүхий хөндийрүүлэх резин гадаргуутай, бариулын хэсгийн урт 0.12м-ээс багагүй. 4. Температурын горим: -40°C-:+40°C 5. 0.2-:-1кВ хүчдэлтэй, 50Гц давтамжтай тоноглолд хүрч ажиллахад хүний аюулгүй байдлыг хангаж, дуут гэрлэн дохио өгнө 6. Дуут гэрлэн дохиог ажиллуулах дотоод /батареи/ тэжээлтэй 7. Хүчдлийн доод мэдрэмж нь 0.025кВ-оос ихгүй 7. Тээврийн байршилд цахилгааны хэлхээний ажлын хэсэг, тусгаарлах хэсэг эвхэгдэн нягтарч механик эвдрэлээс хамгаалагдах, уут савтай байх. 7. 1кВ-оос багагүй туршилтын хүчдлийг даах 8. Жин 0.25кг-аас ихгүй 	<p>Цахилгаан тоноглолын гүйдэл дамжуулах хэсгийн хүчдэлийг тодорхойлоход хүнийг тусгаарлах багаж</p>	<p>Хамгаалах хэрэгслийн техникийн бичиг баримт, эрх бүхий байгууллагаар баталгаажсан зөвшөөрөл, хамгаалах хэрэгсэл гурав хоорондоо тохирсон байна. Ашиглалт болон аюулгүй ажиллагааны зааврыг монгол хэл дээр дагалдуулж өгөх.</p>
6	 <p>Нэг туйлт хүчдэл заагуур /10,6кВ/</p> 	<ol style="list-style-type: none"> 1. Хүчдэл заагуурын урт /сунгасан үед/ 0.8м-ээс ихгүй, тээврийн байрлалд /эвхсэн үед/ 0.42м-ээс ихгүй 2. Тусгаарлах хэсэг /ажлын хэсгээс бариул хүртэлх/ цахилгаан гүйдэл дамжуулахгүй тусгаарлах материал /бакелит, пластмас, мод, тос шингээсэн тусгаарлагч/ -аар хийгдсэн, тусгаарлах хэсгийн урт 0.24м –ээс багагүй 3. Бариулын хэсэг /гар хүрч харьцах/ тусгаарлах материалтай, гар гулгахгүй хэлбэр бүхий хөндийрүүлэх резин гадаргуутай, бариулын хэсгийн урт 0.12м-ээс багагүй. 4. Температурын горим: -40°C-:+40°C 5. 6-:-10кВ хүчдэлтэй, 50Гц давтамжтай тоноглолд хүрч ажиллахад хүний аюулгүй байдлыг хангаж, дуут гэрлэн дохио өгнө 6. Дуут гэрлэн дохиог ажиллуулах дотоод /батареи/ тэжээлтэй 7. Хүчдлийн доод мэдрэмж нь 1.3кВ-оос ихгүй 7. Тээврийн байршилд цахилгааны хэлхээний ажлын хэсэг, тусгаарлах хэсэг эвхэгдэн нягтарч механик эвдрэлээс хамгаалагдах, уут савтай байх. 7. 40кВ-оос багагүй туршилтын хүчдлийг даах 8. Жин 0.42кг-аас ихгүй 	<p>Цахилгаан тоноглолын гүйдэл дамжуулах хэсгийн хүчдэлийг тодорхойлоход хүнийг тусгаарлах багаж</p>	<p>Хамгаалах хэрэгслийн техникийн бичиг баримт, эрх бүхий байгууллагаар баталгаажсан зөвшөөрөл, хамгаалах хэрэгсэл гурав хоорондоо тохирсон байна. Ашиглалт болон аюулгүй ажиллагааны зааврыг монгол хэл дээр дагалдуулж өгөх.</p>

7	 <p>Машин механизмын зөөврийн газардуулга /1-:-35кВ/</p>	<ol style="list-style-type: none"> 1. Машин механизмын зөөврийн газардуулга нь механизмын тоноглолд хүрч холбоос үүсгэх бариултай хавчаар 1ш, газардуулгын дамжуулагч утас 1ш, газардуулгын гадсанд бэхлэх хавчаар 1ш, газардуулгын гадас 1ш -с бүрдэнэ. 2. Механизмын тоноглолд хүрч холбоос үүсгэх хавчаар нь металл хийцтэй, найрлага нь гангаар хийгдсэн, нунтаг паалангаар хучсан, зэврэлтэнд тэсвэртэй, ажлын хэсгийн урт 0.12м орчим, хавчилтыг тохируулах чангалагчтай. Бариул хэсэг нь цахилгаан гүйдэл дамжуулахгүй тусгаарлах материал /бакелит, пластмас, мод, тос шингээсэн тусгаарлагч, эпоксит лакан бүрхүүлтэй/ -аар хийгдсэн, барих гадаргуу /гар хүрч харьцах/ нь гар гулгахгүй хэлбэр бүхий хөндийрүүлэх резин материалтай, 0.3м-ээс багагүй урттай. Их бие дээрээ газардуулгын утас бэхлэгчтэй. 3. Газардуулгын дамжуулагч утас 16мм²-аас багагүй хөндлөн огтлолтой, 4.0 м-ээс багагүй урттай, уян зэс утас. Уян зэс утасны гадна тусгаарлага бүрхүүл нь тунгалаг полимер, чийгэнд тэсвэртэй, уян хатан чанартай, үрэлтэнд тэсвэртэй, хүйтэнд хөшүүн болохгүй хөлдөж хагарахгүй шинж чанартай. 4. Газардуулгын гадсанд бэхлэх хавчаар нь /гадсанд хүрч холбоос үүсгэх/ металл хийцтэй, найрлага нь гангаар хийгдсэн, нунтаг паалангаар хучсан, зэврэлтэнд тэсвэртэй, хавчилтыг тохируулах чангалагчтай, их бие дээрээ газардуулгын утас бэхлэгчтэй. 5. Газардуулгын гадас хатуу металл хийцтэй, зэвэрдэггүй материалын орцтой, цохилт шингээх толгой хэсэгтэй, хөрсөнд орох шовх үзүүртэй, 20мм²-аас багагүй диаметртай, 1м-ээс багагүй урттай. 6. Ажиллах температурын горим: -45⁰С-:-+45⁰С 7. Механизмын зөөврийн газардуулгыг задалж салган овор хэмжээг багасгах боломжтой, уут савтай байна. 8. 35кВ хүртэл хүчдэлтэй, 50Гц давтамжтай тоноглолд хүрч ажиллахад хүний аюулгүй байдлыг хангах 9. Жин 4.7 кг-аас ихгүй 	<p>Механизмын үлдэгдэл цэнэгийг шавхах зориулалттай багаж</p>	<p>Хамгаалах хэрэгслийн техникийн бичиг баримт, эрх бүхий байгууллагаар баталгаажсан зөвшөөрөл, хамгаалах хэрэгсэл гурав хоорондоо тохирсон байна. Ашиглалт болон аюулгүй ажиллагааны зааврыг монгол хэл дээр дагалдуулж өгөх.</p>
---	--	--	---	--

8	 <p>Амьсгалын замыг хамгаалах хэрэгсэл /тоосноос хамгаалах, олон удаа ашиглах хошуувч/</p>	<p>MNS 5620-2006 Амьсгалын замын хамгаалалтын хэрэслийн норм EN 149, 146, 141, 140, 143, 148 стандарт нормын шаардлагыг хангасан байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1.Хамгаалах чадвар FFP-2 үзүүлэлтийг хангасан байх / MNS5620-2006 8.2.1.1/ 2.Тоосноос хамгаалах шүүгчийн давхар нь 10 ба түүнээс дээш, эсвэл сольдог шүүлтүүртэй /PM10, PM2.5, NO2, SO2, O3 шүүх үзүүлэлтийг дангаар буюу хавсарсан байдлаар хангасан/ байх, хөлөргөхгүй, харшлахгүй, амьсгалахад саадгүй чөлөөтэй байх. 3.Энгийн загвартай бол хамрын хянганы даруулга төмөр тохируулагчтай, амьсгал гаргах хавхлаг / клапан/-тай байх. 4.Хошуувч нано технологиор хийгдсэн, амархан цэвэрлэх боломжтой материалтай бол клапангүй, сольдог шүүлтүүргүй байж болно. 5.Толгойд чихний ардуур бэхлэх 2 уяа буюу гогцоотой /сунамтгай уян шинж чанартай/ байх. 6.Хөнгөн, уян хатан, хүний нүүрний хэлбэрт зохицсон, хялбар цэвэрлэх боломжтой, бараан буюу хар өнгөтэй байх. 	<p>Үйлдвэрийн тоос тоосонцор, химийн бодис, утаа угаар болон хорт хийнээс амьсгалын замын эрхтэнийг хамгаалах хэрэгсэл.</p>	<p>Хошуувчны үйлдвэрлэгчийн техникийн өгөгдөл, хошуувч дээрх бичлэг бичилт, хошуувчны пайз буюу дагалдах бичиг баримт /сертификат/ хоорондоо тохирсон байна. Захиалгын нийт тоо ширхэгт тааруулан хошуувчны төрөл бүрийн загваруудыг хольж оруулсан байж болно.</p>
---	--	--	---	---

Нийлүүлэгдэх барааны хувьд үйлдвэрийн болон бусад шалгалт, туршилтын жагсаалт хангаж байгаа эсэхийг техникийн үзүүлэлт бүрээр нотолсон үйлдвэрийн баримт /техникийн өгөгдөл буюу паспорт/, холбоо барих хаяг, майл хаягыг заавал ирүүлнэ.

Захиалагч талын тухайн бараа хариуцсан мэргэжилтэн, холбогдох хүмүүс бараа хүлээн авах явцад баримт бичгийн бүрдэл , гэрчилгээ зэрэг холбогдох бичиг баримттай тулгаж шалгана . Шаардлагатай бол шинжилгээнд хамруулж дүгнэлт үндэслэнэ.

Шалгалт, туршилтаар бараа нь техникийн тодорхойлолтыг хангаагүй тохиолдолд барааг буцаах ба тус барааг сольж өгнө. Үүнтэй холбоотой гарах зардлыг захиалагч тал хариуцахгүй.

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|--|---|
| 1. Шалгах болон турших | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа: 12 сар байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш 90 хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1)
- 1.1. **Барааг хүлээлгэн өгөхдөө холбогдох эрх бүхий албан тушаалтанд шалгуулж, зөвшөөрлийг авсан байна.**
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)
- 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
 - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
 - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
 - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ, туршилтын протокол ирүүлнэ.
 - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна. Нийлүүлэгч нь гэрээний дагуу нийлүүлэх барааг захиалагчийн захиалгын дагуу тухай бүр нийлүүлнэ. Захиалагын хуудас хүргүүлсэнээс хойш 3-7 хоногийн дотор барааг шуурхай нийлүүлнэ. Захиалагч гэрээнд заасан барааг заавал авах үүрэг хүлээхгүй Тухайн жилийн хэрэгцээ шаардлагын дагуу барааг авч гэрээг дүгнэх.
3. Баталгаат засвар (ГЕН-5)
- 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага: **12 сар** байна.
- [Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]. **Уг хугацаанд баталгаат засвар, чанарын баталгааны хугацаа болгон гэрээний үнийн дүнгийн 5 хувийн мөнгөн дүнг авч үлдэнэ.**
4. Төлбөр (ГЕН – 7)
- 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Гэрээний үнийг барааг хүлээн авсан акт, гэрээ дүгнэсэн протокол болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичиг, гэрээ дүгнэсэн протокол зэргийг үндэслэн төлбөрийг тухай бүрт гүйцэтгэлээр төлж болно..
5. Алданги оногдуулах (ГЕН - 9)¹
- 9.1. Алданги оногдуулах хувь: **Хоногт гэрээний үнийн дүнгийн 0,1 % байна.**
- Алдангийн нийт дүн: **Гэрээний үнийн дүнгийн 10 % байна.**

¹ Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

ЗАХИАЛАГЧ	НИЙЛҮҮЛЭГЧ
_____	_____
(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
_____	_____
(Гарын үсэг)	(Гарын үсэг)
_____	_____
(Албан тушаал)	(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын ____ -наас _____ оны __ дугаар сарын ____ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг³;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

² Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

³ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]